



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА  
ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО  
(ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА)

**Хөрөнгийн зах зээлийн  
өнөөгийн байдал болон цаашдын  
хөгжлийн бодлогын талаарх  
санал асуулгын тайлан**


# АГУУЛГА

- Судалгааны арга зүй
- Судалгаанд хамрагдагсад
- Хөрөнгийн зах зээлийг үнэлэх нь
- Төрийн оролцоог үнэлэх нь
- Хөгжлийн гарцыг эрэлхийлэх нь

# Түүвэрлэлт

Санал асуулгад оролцогчдыг брокер дилерийн компаниар дамжуулан сонгосон. Брокер дилерийн компаниудын харилцагчийн тоог Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс хүсэлт хүргүүлэн авч брокер дилерийн компанийн харилцагчийн тоог жигд төлөөлөх зорилгоготойгоор компаниудыг 4 ангилж, ангилал тус бүрээс тэнцүү төлөөлөл байхаар санамсаргүй түүвэрлэлт хийсэн.

## Санал асуулгад оролцогчийн тоо, харилцагч компаниар



# Асуулга боловсруулалт

Санал асуулгын асуулга нь хөрөнгө оруулагчийн тухай мэдээлэл, үнэт цаасны арилжаанд оролцогчийн талаарх мэдээлэл, үнэт цаасны арилжаанд оролцож байсан туршлага, харилцагч компанийн талаарх санал, үнэт цаасны зах зээлд оролцогч төрийн байгууллагын талаарх санал, үнэт цаасны зах зээлийн цаашдын чиг хандлага, хөгжлийн бодлогын талаар дэвшүүлэх санал зэрэг 4 бүлэг 31 асуулттай. Асуулгыг Спүүнмедиа ХХК болон Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо хамтран боловсруулсан.


## Санал асуулгын асуултууд, бүлгээр

Үнэт цаасны арилжаанд орж байсан туршлага	Хөрөнгийн зах зээлийг үнэлэх нь	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдал	Хөгжлийн бодлогын талаар санал	Судалгаанд оролцогчийн мэдээлэл
<ul style="list-style-type: none"> <li>•Анхны үнэт цаасаа авсан огноо</li> <li>•Анхны арилжаалж байсан хувьцаа</li> <li>•Хувьцаат компанийн санхүүгийн тайлантай танилцдаг эсэх</li> <li>•Санхүүгийн тайланд итгэдэг эсэх</li> <li>•Хувьцаанд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ</li> <li>•Арилжаанд оролцдог давтамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Үнэт цаасны компани мэдээллээр сайн хангаж чаддаг эсэх</li> <li>•Үнэт цаасны компаний өгч буй мэдээлэлд итгэдэг эсэх</li> <li>•Итгэдэггүй шалтгаан</li> <li>•Авахыг хүсч буй мэдээллийн төрөл</li> <li>•Үйлчлүүлдэг үнэт цаасны компани</li> <li>•Олон үнэт цаасны компаниар үйлчлүүлдэг эсэх</li> <li>•Данс нээх хаахад үүсдэг төвөгтэй асуудал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Санхүүгийн тайланг хянах ёстой байгууллагыг мэддэг эсэх</li> <li>•Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай эсэх</li> <li>•Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай эсэх</li> <li>•Хөрөнгийн биржийн хувьчлахыг дэмждэг эсэх</li> <li>•Төрийн байгууллагын албан тушаалын томилгоо оновчтой байж чадаж байгаа эсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Эрдэнэс таван толгойн хувьцаа үр өгөөж өгнө гэдэг итгэдэг эсэх</li> <li>•Эрдэнэс таван толгойн хувьцаагаа арилжихыг хүсч байгаа эсэх</li> <li>•Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд өгөх үнэлгээ</li> <li>•Үнэт цаасны зах зээлийн хөгжилд нөлөөлж буй саад бэрхшээл</li> <li>•Үнэт цаасны зах зээлийг ирээдүйд хөгжинө гэдэгт итгэдэг эсэх</li> <li>•Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар санал бодол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Нас</li> <li>•Хүйс</li> <li>•Боловсрол</li> <li>•Ажил эрхлэлт</li> <li>•Байршил</li> </ul>

# Мэдээлэл цуглуулалт

Санал асуулгыг Google Forms онлайн платформын тусламжтайгаар үнэт цаасны арилжаа эрхлэгч компаниудаар дамжуулан хөрөнгө оруулагчдын цахим шуудан руу илгээж, илгээсэн тухай мэдээллийг утсаар залган мэдэгдэж бөглүүлсэн. Санал асуулга 2016 оны 9 дүгээр сарын 13нд эхэлж дөрвөн долоо хоног үргэлжлээд 2016 оны 10 дугаар сарын 7нд дууссан.


## Бөглөсөн санал асуулгын тоо, өдрөөр



# Төлөөлөх чадвар

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь арилжаанд идэвхтэй оролцдог хөрөнгө оруулагчид байсан. Монгол улсад сүүлийн жилүүдэд 4113 иргэн, аж ахуй нэгжүүд арилжаанд идэвхтэй оролцдог байдаг. Санал асуулгад гадаадын 4, дотоодын 156 хөрөнгө оруулагчид хамрагдсан. Уг түүвэр олонлог нь нийт хувьцааны арилжаанд оролцогчдыг 95%-ийн итгэх магадлалтай  $\pm 7.6\%$ -иас ихгүй хазайлттай төлөөлөх чадвартай.

## Хувьцааны арилжаанд оролцогчдын тоо, мянгаар




Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

# Нас, хүйсний бүтэц

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 68% нь эрэгтэй байгаа нь үнэт цаасны зах зээлийн онцлогтой холбоотой. Гол төлөв 30-34 насныхан түлхүү хамрагдсан нь Монгол улсын хүн амын насны бүтэцтэй дүйж байна.

Санал асуулгад оролцогчдын хүн амын суварга




# Боловсрол, ажил эрхлэлт

Судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь дээд боловсролтой бөгөөд ихэнх нь буюу 59% нь хувийн байгууллагад ажилладаг.

## Санал асуулгад оролцогчдын ажил эрхлэлтийн байдал



## Санал асуулгад оролцогчдын боловсролын түвшин






# Үнэт цаас арилжаалж байсан байдал

Судалгаанд дийлэнх нь буюу 69% нь 5 сая төгрөг хүртэлх хэмжээний үнэт цаас худалдаж авч байсан хөрөнгө оруулагчид хамрагдсан байна.


## Үнэт цаасанд хөрөнгө оруулсан хэмжээ




# Үнэт цаас арилжаалж байсан байдал

Судалгаанд оролцогчдын 56% нь сүүлийн жилд ямар нэгэн байдлаар арилжаанд орж байсан, 45% нь анхны хувьцаагаа жилийн өмнө худалдаж авч байсан нь идэвхтэй бөгөөд шинэ хөрөнгө оруулагчид түлхүү хамрагдсаныг илтгэнэ.

## Анхны үнэт цаасаа авч байсан хугацаа




## Арилжаанд оролцдог давтамж




# Үнэт цаасны арилжаанд орж байсан туршлага

Хөрөнгө оруулагчид санхүүгийн тайлантай танилцах нь төдийлөн түгээмэл биш байна. Судалгаанд оролцогчдын 57% нь л хувьцаат компаний санхүүгийн тайлантай танилцаж байжээ. Хувьцаат компаниудын санхүүгийн тайланд хөрөнгө оруулагчид тийм ч итгэлтэй бус аж. Санал асуулгад оролцогчдын 32% нь санхүүгийн тайлангийн итгэлтэй байдалд дундаж үнэлгээ өглөө.

## Хувьцаат компаний санхүүгийн тайлантай танилцдаг эсэх




## Санхүүгийн тайланд итгэсэн эсэх, 1-5 оноогоор



# Үнэт цаасны компанийн сэтгэл ханамж

Үнэт цаасны компаниуд хөрөнгө оруулагчдыг хэрэгтэй мэдээллээр төдийлөн хангаж чаддаггүй аж. Судалгаанд оролцогчдын 73% нь мэдээллээр хангах байдалд дунд буюу түүнээс доош үнэлгээ өгчээ. Хөрөнгө оруулагчид компанитай холбоотой мэдээллийг цаг алдалгүй мэдэж байхыг хүсэхээс гадна тухайн салбар, зах зээлийн онцлогийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг хүсэмжилж байна.

## Үнэт цаасны компани мэдээллээр сайн хангаж чаддаг эсэх



Чаддаггүй Чаддаг


## Авахыг хүсч буй мэдээлэл



# ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Үнэт цаасны компаниудын гаргаж өгдөг мэдээллийн чанарыг хангалтгүй гэж үздэг байна. Судалгаанд оролцогчдын 68% нь үнэт цаасны компанийн мэдээллийн чанарт дунд буюу түүнээс доош үнэлгээ өгчээ. Мэдээлэлд итгэдэггүй шалтгаан нь мэдээлэл маш хоцорч ирдэг ба сонин дээр тавигддаг мэдээллийг өгдөг, мөн хэрэглэгчтэйгээ тулж харьцдаггүй гэсэн шалтгаан давамгайлж байв.

## Үнэт цаасны компанийн мэдээлэлд итгэдэг эсэх



## Итгэдэггүй шалтгаан




# Үнэт цаасны компанийн сэтгэл ханамж

Хөрөнгө оруулагчдын дийлэнх нь данс нээх, хаах, арилжаанд ороход гардаг чирэгдэл хүндрэлийг арилгаж интернэт платформтой болохыг хүсэмжилж байна. Олон үнэт цаасны компаниар үйлчлүүлэх нь тийм ч түгээмэл биш буюу хөрөнгө оруулагчдын 71% нь зөвхөн нэг компаниар үйлчлүүлдэг аж.

## Арилжаанд ороход үүсдэг хүндрэл




## Үйлчлүүлдэг үнэт цаасны компаний тоо




# Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэгдэл

Хөрөнгө оруулагчдын тэн хагас нь хувьцаат компанийн санхүүгийн тайланг хянах ёстой субъектийг санхүүгийн зохицуулах хороо гэж тодорхойлсон бөгөөд үйл ажиллагаанд туйлын хангалтгүй гэсэн үнэлгээ өгөв.

## Хувьцаат компанийн санхүүгийн тайланг хянах ёстой этгээдийг нэрлэсэн нь




## Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд өгч буй үнэлгээ



# Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэгдэл


Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулагчид сэтгэл ханамжгүй байна. Судалгаанд оролцогчдын 86% нь дунд буюу муу үнэлгээ өгөв. Хөрөнгийн биржийг дийлэнх олонх нь буюу 89% нь ямар нэгэн байдлаар хувьчлахыг дэмжиж байна.

## Хөрөнгийн бирж цаг тухайд мэдээллэр хангаж чаддаг эсэх



Чаддаггүй Чаддаг

## Хөрөнгийн биржийг хувьчлах ёстой юу? Хувьчлах ёстой бол хэдэн хувийг






# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Хөрөнгө оруулагчид үнэт цаасны зах зээлийн хөгжиж чадахгүй байгаа хамгийн чухал асуудлыг төрийн нэгдсэн бодлого байхгүй гэж үзэв. Хөрөнгийн зах зээлд төрийн оролцоог багасгаж, хөрөнгийн биржийг хувьчлах, татварын орчинг таатай болгох, сайн бүтээгдэхүүн гаргах, олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих зараг аргуудыг санал болгов.

## Үнэт цаасны зах зээлийн хөгжилд хамгийн тээг болж буй асуудал




## Цаашид яавал үнэт цаасны зах зээл хөгжих вэ?




# Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн бодлогын талаар

Хөрөнгө оруулагчдын талаас их нь Эрдэнэс таван толгойн хувьцаа үр өгөөжөө өгнө гэж боддог ба мөн хувьцаагаа арилжаалахыг хүсч байгаа аж.

**Эрдэнэс таван толгойн хувьцаа өгөөжөө өгнө  
гэдэгт итгэдэг эсэх**




**Эрдэнэс таван толгойн хувьцаагаа  
арилжихыг хүсч байгаа эсэх**




# Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн бодлогын талаар

Монголын үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг туйлын муу гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдоос өнөөгийн нөхцөл байдалд сайн гэсэн үнэлгээ өгөх хөрөнгө оруулагч байсангүй. Хэдий тийм ч цаашид хөрөнгийн зах зээл хөгжих бүрэн боломжтой гэж хөрөнгө оруулагчид үзэж байна.

## Үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдалд үнэлгээ өгвөл



## Үнэт цаасны зах зээл цаашид хөгжих боломжтой юу?



# Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн бодлогын талаар

“...2. Томоохон төслүүдэд шаардагдах хөрөнгийг биржээр босгох  
3. Эрдэнэт ГОК, ба Төрийн банкны хувьцааг хөрөнгийн биржээр худалдах...”  
*Эрэгтэй, 62 настай*

“... төрөөс хувьчлалыг үнэ хаялцуулах аргаар биш 2дагч зах зээлээр олон  
нийтэд нээлттэй борлуулах...”  
*Эрэгтэй, 55 настай*

“... ХЗЗ дээр үнэт цаасаа гаргаж буй компаниудыг дэмжих, татварын  
хөнгөлөлт эдлүүлэх... зэрэг шинэ бүтээгдэхүүн гаргах мотиваци төрүүлэх  
хэрэгтэй байна”

*Эрэгтэй, 35 настай*

# Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн бодлогын талаар

“Банкнүүдын хэт монополь байдлыг сулруулах”

*Эрэгтэй, 38 настай*

“Маш сайн мэдээлэл ард түмэнд хүргэх, үнэт цаасны зах зээлийн талаарх ойлголтыг хүн бүр мэддэг болох”

*Эмэгтэй, 36 настай*